



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

*Хууль зүйн сайдын төсвийн багцын 2014 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит*

Аудитын код: УАГ-2015/21/СТА-ТЕЗ

Улаанбаатар хот

2015 оны 4 дүгээр сар



ХУУЛЬ ЗҮЙН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

АГУУЛГА

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

YAG-ын Санхүүгийн аудитын газрын
дарга,
Тэргүүлэх аудитор С.Энхзаяа

Утас: 261663
Цахим хаяг: enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Л.Одгэрэл
Утас: 260512
Цахим хаяг: odgerell@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Болормаа
Утас: 261628
Цахим хаяг: bolormaab@audit.gov.mn

Үндэсний Аудитын Газар

Засгийн газрын IV байр
Бага тойруу-3
Улаанбаатар-15160
Монгол улс

Цахим хуудас: www.audit.mn

Аудитын тайлан

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
Байгууллагын хууль, эрх зүйн орчин
Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн
горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний
үр дүн
Дотоод хяналт
Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх
тайлбар
Шилэн дансны мэдээлэл
лж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар
Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг
шийдвэрлэсэн талаар
Анхаарал татахуйц бусад чухал асуудал
Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн
нэгтгэл
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Зөвлөмж
Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Менежментийн захидал

Аудитын гэрчилгээ

Аудит хийсэн санхүүгийн тайлан
Төсвийн гүйцэтгэлийн тайлан

2015 оны 4 дүгээр сар

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хууль зүйн сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийв.

Хууль зүйн сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хууль зүйн сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2014 оны 4 дүгээр сарын 5-наас 2014 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Болормаа хэрэгжүүлэв.

Хууль зүйн сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2014 оны 4 дүгээр сарын 5-наас 2014 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг хуулийн хугацаанд Хууль зүйн яамны удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Хууль зүйн сайд төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд төсөв боловсруулж, батлуулах, гүйцэтгэлийг хангах, тайлагнах үйл ажиллагааг төсвийн болон төрийн болон орон нутгийн өмч, санхүү, нягтлан бодох бүртгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн орчны хүрээнд хэрэгжүүлж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт томоохон өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу Засгийн газрын 2012 оны 63 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль зүйн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т “Хууль зүйн яамны үйл ажиллагааны яамны эрхэм зорилго нь Монгол Улсад шударга ёс, хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлж, төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэхэд оршино” гэж заажээ.

Уг зорилгыг хангахад чиглэсэн хүний эрх, эрх чөлөөг хангах эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, түүний хэрэгжилтийг хууль сахиулах болон дотоод хэргийн салбарт бүрэн хангаж хэвшүүлэх дараах чиглэлийг эрхэмлэн ажилладаг байна.Үүнд:

- Хууль тогтоомжийг боловсруулах хэлэлцүүлэх шатанд зайлшгүй хийх агуулгын болон хэлбэрийн ажилбар-(эдийн засгийн үр ашгийн тооцоо, эрх ашиг нь хөндөгсдийн саналыг, сонсох, нэр томьёо, бичвэрийн хууль зүйн техникийг хангах зэрэг)-уудыг хуульчлан журамлах;
- Төрийн нэрийн өмнөөс хүний эрх, эрх чөлөөг хөндөх цагдаа, хил хамгаалах, гааль, мэргэжлийн хяналтын зэрэг байгууллагын үйл ажиллагааны уялдааг хангах;
- Шүүх эрх мэдлийн салбар дахь шинэтгэлийн хүрээнд батлагдсан багц хуулийн Хууль зүйн салбар дахь хэрэгжилтийг хангах, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх, чанарыг сайжруулах;
- Иргэний нийгмийн оролцоог зохистой хэмжээнд хангах замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэй тэмцэх механизмыг сайжруулах;
- Төрийн байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг хариуцлагыг өндөржүүлж, мэдээллийн ил тод, нээлттэй шуурхай байдлыг хангуулах замаар нийтийн алба төлөвшүүлэх орчныг бий болгох;
- Салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, эрх зүйн мэдээлэл сурталчилгаа, боловсрол хүний нөөцийн сургалтын уялдаа холбоог сайжруулах;
- Улсын хил хамгаалалт, Улсын бүртгэл мэдээлэл, Гадаадын иргэн, харьяатын асуудлыг эрхлэх тогтолцоог боловсронгуй болгож, олон улсын жишигт хүргэх.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу Хууль зүйн сайд Төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Хууль зүйн сайдын 2014 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Хууль зүйн сайдын санхүүгийн нэгтгэсэн тайланд Цагдаагийн ерөнхий газрын 42 төсвийн шууд захирагч, 2 улсын төсөвт үйлдвэрийн газар, Хил хамгаалах ерөнхий газрын 28 төсвийн шууд захирагч, 3 улсын төсөвт үйлдвэрийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 57 төсвийн шууд захирагч, 5 улсын төсөвт үйлдвэрийн газар, Улсын

бүртгэлийн ерөнхий газрын 23 төсвийн шууд захирагч, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 23 төсвийн шууд захирагч, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын 8 төсвийн шууд захирагч, Тахарын ерөнхий газрын 11 төсвийн шууд захирагч, Хууль зүйн яам, Архивын ерөнхий газар, Хууль сахиулахын их сургууль, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хууль зүйн туслалцааны төв, Хорихын нэгдсэн эмнэлэг, Мэдээлэл, шуурхай удирдлагын төв, Банк хадгаламж зээлийн хоршооны ажлын алба, Архидан согтуурахтай тэмцэх сан, нийт 211 байгууллага хамрагдсан болно.

Дээрх байгууллагын 20-д Үндэсний аудитын газар, 125-д орон нутгийн аудитын газар, 9-д хараат бус аудитын компани санхүүгийн аудит хийж дүгнэлт гаргасан байна.

Аудитад хамрагдсан байгууллагын 142 байгууллага нь “зөрчилгүй”, 4,943.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй (Монгол тамга УТҮГ, Увс аймгийн улсын бүртгэлийн алба, Говь-Алтай аймгийн улсын бүртгэлийн алба, Говь-Алтай аймгийн Шүүхийн шинжилгээний алба, Орхон аймгийн Иргэний харьяалал шилжилт хөдөлгөөний алба, Архидан согтуурахтай тэмцэх сан, Сэлэнгэ аймгийн цагдан хорих 433 дугаар анги, Говь-Алтай аймгийн Шийдвэр гүйцэтгэлийн алба, Сүхбаатар аймгийн Шийдвэр гүйцэтгэлийн алба, Шохой тоосгоны нэгдэл ТӨҮҮлдвэр, Сэлэнгэ аймгийн Хөтөлийн шийдвэр гүйцэтгэлийн хэсэг) 11 байгууллага “хязгаарлалттай” дүгнэлт, 1,321.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Нийслэлийн шийдвэр гүйцэтгэлийн алба газарт “сөрөг”, 169.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Газар Ивээл” Улсын төсөвт үйлдвэрийн газарт “дүгнэлт өгөхөөс татгалзсан” байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 8 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Горим сорил хэрэгжүүлэхэд явцад бий болсон үр дүнгийн талаар ажлын баримтаар баталгаажуулж, цаашид анхаарах зарим асуудлыг энэ тайлангийн 2.10-д тусгав.

2.5 Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хууль зүйн сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 7-г гүйцэтгэв.

Хууль зүйн сайдын салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж байна.

Хууль зүйн сайдын төсвийн багцын санхүүгийн нэгтгэсэн тайланг “PLASTIC” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг төлөвлөсөн горимын дагуу сорьсон.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд Хууль зүйн сайдын төсвийн багцын дотоод хяналтыг системийн эрсдэлийг “дунд” гэж тооцсон болно.

Системийн хэмжээнд санхүү, бүртгэлийн үйл ажиллагааны явцад хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчил, өгсөн зөвлөмжийг нэгтгэсэн дүнгээс үзэхэд дотоод хяналтын системийг өөрийн байгууллагын онцлогыг тусгаж, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт оруулах замаар боловсронгуй болгох шаардлагатай байна.

Батлагдсан төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Хууль зүйн сайдын багцад Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар урсгал зардалд 346.5 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 27.3 тэрбум төгрөг, эргэн төлөгдөх цэвэр зээлд 22.2 тэрбум төгрөг, улсын төсвөөс 361.4 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 0.8 тэрбум төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 5.7 тэрбум төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 5.9 тэрбум төгрөг, нийт 373.8 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Төсвийн тухай хуулийн дагуу Сангийн сайдын тушаалаар төсвийн зарлага, санхүүжилтийн хуваарийг баталж 2014 онд урсгал зардалд 325.0 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 25.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс, үндсэн үйл ажиллагааны орлогоос 7.2 тэрбум төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 2.8 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 0.8 тэрбум төгрөг, нийт 361.5 тэрбум төгрөгийн зардлыг санхүүжүүлжээ.

Үүнээс 2014 онд улсын төсвөөс урсгал зардалд 325.0 тэрбум төгрөг олгосноос 317.8 тэрбум төгрөгийг зарцуулж үлдэгдэл 7.2 тэрбум төгрөгийг Төсвийн тухай хуулийн дагуу Сангийн яам татан төвлөрүүлж, мөн хөрөнгө оруулалтын зардалд 25.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 25.7 тэрбум төгрөгийг бүрэн зарцуулсан байна. Хууль зүйн сайдын төсвийн багцын 2014 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг хавсралтаар үзүүлэв.

Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Хууль зүйн сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 451,928.0 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 9,038.6 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажууллаа.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар

Хууль зүйн сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн дүнтэй дансанд гарсан ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

Аудитын явцад илрүүлсэн гол зөрчлүүд, гаргасан шийдлүүд

Төрийн аудитын байгууллага Хууль зүйн сайдын харъяа 26 төсвийн шууд захирагчийн 2014 оны санхүүгийн тайланд аудит хийж, санал дүгнэлт гаргасан бөгөөд аудитын явцад илрүүлсэн зөрчил дутагдалд нэгтгэсэн байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Хууль зүйн сайдын төсвийн багцад хамаардаг төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагч, төсөл сан, төрийн өмчит үйлдвэрийн газруудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг нэгтгэсэн байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг энэ тайлангийн 2.14-д хураангуйлан тэмдэглэв.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хууль зүйн сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд анхаарал татах асуудал нь 49.6 тэрбум төгрөгийн авлага тусгагдсны дийлэнх хувийг Банк, хадгаламж зээлийн хоршооны ажлын албаны 41.2 тэрбум төгрөгийн авлага эзэлж байна.

Мөн 75.4 тэрбум төгрөгийн өглөг тусгагдсан бөгөөд үүний дийлэнх хувийг Банк, хадгаламж зээлийн хоршооны ажлын албаны 50.8 тэрбум төгрөг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 7.7 тэрбум төгрөгийн өглөг, Цагдаагийн ерөнхий газрын өглөг 0.9 тэрбум төгрөг, Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн цэргийн 0119 дүгээр анги буюу улсын төсөвт үйлдвэрийн газрын 13.9 тэрбум төгрөг, бусад байгууллагын 2.1 тэрбум төгрөгийн өглөг тус тус эзэлж байна.

Хууль зүйн сайдын санхүүгийн нэгтгэсэн тайланд Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгийн хөрөнгийг 2014 оны санхүүгийн тайланг тусгасан тухай

Засгийн газрын 2012 оны "Цэргийн анги нэгтгэлийг өөрчлөн зохион байгуулах тухай" 122 дугаар тогтоолоор Төрийн өмчийн хорооны 2013 оны "Хаалтын баланс батлах тухай" 187 дугаар тогтоол гарч Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн /хуучин нэрээр/ хаалтын санхүүгийн тайлан, Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлгийн эхлэлтийн санхүүгийн тайланг баталгаажуулж, Батлан хамгаалах хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлгийн эхлэлтийн санхүүгийн тайланд MRI, CT оношлогооны 2 аппарат 3,320.4 сая төгрөгийг авлагаар бүртгэгдсэн байна.

Мөн Засгийн газрын 2013 оны "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 166 дугаар тогтоолын дагуу Төрийн өмчийн хорооны 2013 оны "Дуусаагүй барилга балансаас балансад шилжүүлэн бүртгэлд авах зөвшөөрөл олгох тухай" тогтоол гарч тус эмнэлгийн дуусаагүй барилгыг Хууль зүйн яаманд үнэ төлбөргүй шилжүүлэх шийдвэр гарсны дагуу Хууль зүйн салбарын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн /хуучнаар/ аудит хийсэн санхүүгийн тайланг нэгтгэхдээ үндсэн хөрөнгө, бараа материал, өр, авлагыг Батлан хамгаалах хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлэгт, дуусаагүй барилгыг Хууль зүйн яаманд шилжүүлэн хаалт хийж дуусгавар болгосон байна.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн эмнэлэгт MRI, CT оношлогооны 2 аппарат нийлүүлэх тендер зардагдаж, тендерийн ялагч "Пролианс" ХХК-тай "Эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах" 3,219.9 сая төгрөгийн ТТАХНЭ 11/01/01 тоот гэрээг байгуулж, 2012 оны 6 дугаар сард "ТТАХНЭмнэлэгт компьютер томографын аппарат/CT/,цахилгаан соронзон давтамжит оношлогооны аппарат /MRI/ худалдан авах захиалагч, нийлүүлэгчийн хооронд байгуулах гэрээ" ТТАХНЭмнэлэг-11/01-01 тоот гэрээний нэмэлт гэрээ АГГ/2012-06 дугаар гэрээгээр тоног төхөөрөмжийн суурилуултын үнэ болох 160.0 сая төгрөгийг нэмж байгуулсан байна.

Тус эмнэлгийн дуусаагүй барилгын анхны гэрээг 2010 онд 9,142.5 сая төгрөгөөр байгуулж, 2012 онд нэмэлт гэрээ байгуулж гэрээний дүнг 10,100.0 сая төгрөг болгон тодотгосон бөгөөд 2012 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэгч компанид 8.3 тэрбум төгрөгийг гүйцэтгэлийн дагуу олгосон байна. Харин 2012 оны хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг улсын хэмжээнд 2013 оны 03 дугаар сарын 31-ийг хүртэл олгох болсноор үлдэгдэл 1.8 тэрбум төгрөгийг олгох болсон байна.

Энэ хугацаанд ТТАХНЭмнэлэг хаалтын баланс гаргаж БХЯ-нд шилжүүлэх ажиллагаа хийгдэж байсан бөгөөд асуудал эцэслэн шийдэгдэх хүртэл эмнэлгийн данснаас гүйлгээ шилжүүлэг гарах боломжгүй байсан тул Хууль зүйн яамнаас 1.8 тэрбум төгрөгийг гүйцэтгэгчид олгосон байна.

Төрийн өмчийн хорооны 2013 оны 461 дүгээр тогтоолоор уг дуусаагүй барилгыг 8.3 тэрбум төгрөгөөр буюу 2012 оны үлдэгдлээр Хууль зүйн яаманд шилжүүлж, 2013 оны төсөвт тус эмнэлгийн барилгын төсөв 2.5 тэрбум төгрөгийг нэмж тусгасан бөгөөд нийт 12.6 тэрбум төгрөгийг санхүүжилтийг олгосон байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Хууль зүйн сайдын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад төлөвлөсөн горимын дагуу холбогдох чиглэлээр сорил гүйцэтгэсэн бөгөөд Гэмт хэргээс сэргийлэх арга хэмжээний зардалд 2013 онд 1,336.3 сая төгрөг зарцуулсан бол тайлант онд 2,308.9 сая төгрөг төлөвлөж, 817.0 сая төгрөгийг зарцуулсан асуудлыг дараагийн аудитаар шалгах нь зүйтэй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Аудитаар нийт 853.3 сая төгрөгийн зөрчил арилгуулах 45 албан шаардлага, 156.2 сая төгрөгийн 46 төлбөрийн акт тогтоож, 126 асуудлаар 6,346.1 сая төгрөгийн залруулга хийсэн байна. Аудитын тайланд дурдагдсан нийт зөрчлийн 69.9 хувь нь аймаг, нийслэлд, 30.1 хувь нь Хууль зүйн яамны шууд харъяанд байдаг байгууллагуудад хийсэн аудитаар илэрсэн зөрчил байна.

Хууль зүйн сайдын санхүүгийн нэгтгэсэн тайланд 7 төвлөрүүлэн захирагчийн 192 төсвийн шууд захирагч, мөн төсвийн 8 шууд захирагч болон 10 улсын төсөвт үйлдвэрийн газар, 1 сан, нийт 211 байгууллага хамрагдсан байна. Эдгээр байгууллагын 20-д Үндэсний аудитын газар, 125-д орон нутаг дахь аудитын газар, 9-д хараат бус аудитын компани санхүүгийн аудит хийж дүгнэлт гаргасан.

Аудитад хамрагдсан байгууллагын 142-д нь “зөрчилгүй”, 4,943.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11-д “хязгаарлалттай”, 1,321.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1-д “сөрөг” дүгнэлт, 169.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 байгууллагад “аудитын дүгнэлт өгөхөөс татгалзсан” байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төрийн аудитын байгууллага 2013 оны санхүүгийн тайланг баталгаажуулах аудитаар Хууль зүйн сайдын харьяа 200 нэгж салбарт 328 зөвлөмж хүргүүлсэн бөгөөд биелэлтийг шалгахад 303 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 25 зөвлөмж хэрэгжих шатандаа байна. Зөвлөмжийн биелэлтийг холбогдох байгууллагаас албан ёсоор гаргуулж, ажлын баримтанд хавсаргав.

Зөрчилгүй санал дүгнэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар Хууль зүйн сайдын төсвийн багцын байгууллагын хэмжээнд гарсан залруулаагүй алдаа, зөрчлыг нэгтгэж, материаллаг байдлын түвшинтэй харьцуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд зөрчилгүй өгөх санал дүгнэлтийн хэлбэрийг сонгосон болно.

Хууль зүйн сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн шударга илэрхийлэгдсэн байна.

**ХУУЛЬ ЗҮЙН САЙДЫН ТӨСВИЙН
БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол № 1 зүйлс:

Асуудал 1

Аудитын дүнгийн талаар

Асуудал 2

Хариуцлага тооцох талаар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг. Түүнд дотоод хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон ҮАГ-ын санхүүгийн аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь Хууль зүйн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс зөвлөмжүүд маань дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний ойлголтыг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хууль зүйн яамны санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1 Аудитын дүнгийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Аудитаар нийт 853.3 сая төгрөгийн зөрчил арилгуулах 45 албан шаардлага, 156.2 сая төгрөгийн 46 төлбөрийн акт тогтоож, 126 асуудлаар 6,346.1 сая төгрөгийн залруулга хийсэн байна.

Аудитын тайланд дурдагдсан нийт зөрчлийн 69,9 хувь нь аймаг, нийслэлд, 30.1 хувь нь Хууль зүйн яамны шууд харъяанд байдаг байгууллагуудад хийсэн аудитаар илэрсэн зөрчил байна.

ҮАГ-ын зөвлөмж

Аудитаар илэрсэн төлбөр , зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч, цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг Үндэсний аудитын газарт 2015 оны 8 дугаар сарын 30-ны дотор ирүүлэх.

Эрсдэлүүд

Дотоод хяналт сул байгаагаас зөрчил дутагдал гарч санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийг хүлээн зөвшөөрч холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэн:

ҮАГ-ын ажиглалт

Хууль зүйн сайдын санхүүгийн нэгтгэсэн тайланд 7 төвлөрүүлэн захирагчийн 192 төсвийн шууд захирагч, мөн төсвийн 8 шууд захирагч болон 10 улсын төсөвт үйлдвэрийн газар, 1 сан, нийт 211 байгууллага хамрагдсан.

Дээрх байгууллагын 20-д Үндэсний аудитын газар, 125-д орон нутаг дахь аудитын газар, 9-д хараат бус аудитын компани санхүүгийн аудит хийж дүгнэлт гаргасан.

Аудитад хамрагдсан байгууллагын 142 нь “зөрчилгүй”, 4,943.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 нь “хязгаарлалттай”, 1,321.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 байгууллага “сөрөг” дүгнэлт, 169.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 байгууллага аудитын дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн үйл ажиллагааг зохих стандарт, заавар журмын дагуу явуулаагүйгээс санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, ... аудитад нөлөөлөхийг оролдсон, санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар материаллаг шинжтэй зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу “хязгаарлалттай, сөрөг санал дүгнэлт авсан байгууллагын холбогдох албан тушаалтанд арга хэмжээ авч, хариуг Үндэсний аудитын газарт 2014 оны 7 дугаар сарын 30-ны дотор ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийг хүлээн зөвшөөрч, холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН САЙД
Д.ДОРЛИГЖАВ ТАНАА

2015.04.22 № 440
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хууль зүйн сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

Зөрчилгүй санал дүгнэлт

Хууль зүйн сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.



А.ЗАНГАД

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
НИЙТ ДҮН	-	-
МӨНГӨН ХӨРӨНГӨ	15,027,962,448.05	10,548,686,807.61
Кассанд байгаа бэлэн мөнгө	166,201,848.30	50,227,910.32
Төгрөг\ ЖМС	166,201,848.30	50,227,910.32
Банкинд байгаа бэлэн мөнгө	14,852,083,312.25	10,489,952,659.79
Төгрөг	14,852,083,312.25	10,489,952,659.79
Төсөвт байгууллагын харилцах	1,942,116,996.91	448,295,904.48
Төсөвт байгууллын харилцах (Арилжааны банк)	10,795,623,610.35	10,041,656,755.31
Нэмэлт санхүүжилтийн харилцах	2,114,342,704.99	-
Замд яваа мөнгөн хөрөнгө	9,677,287.50	8,506,237.50
АВЛАГА	47,408,112,145.04	49,598,205,379.93
Ажиллагчидтай холбогдсон авлага	20,472,515.93	42,102,855.94
Төлбөртэй үйлчилгээний авлага	43,682,173.86	52,546,405.13
Татаас, санхүүжилт, (бүтээгдэхүүн нийлүүлэлтийн) авлага	10,397,162.34	5,882,204,271.42
Бусад авлага	47,333,560,292.91	43,621,351,847.44
Байгууллагаас авах авлага	46,766,914,484.87	43,215,374,918.46
Гэрэл цахилгааны авлага	1,181,726.08	2,428,546.00
Түлш халаалтын авлага	7,318,131.43	1,584,779.00
Хоолын авлага	1,184,232.44	-
Шуудан холбооны авлага	1,629,254.66	-
Бусад зардлын тооцооны авлага	46,755,601,140.26	43,211,361,593.46
Хувь хүмүүсээс авах авлага	566,645,808.04	405,976,928.98
УРЬДЧИЛГАА	5,706,257,317.55	3,139,469,295.91
Бусад урьдчилгаа	5,706,257,317.55	3,139,469,295.91
Урьдчилгаа тооцоо	336,366,401.15	889,155,980.41
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	321,730,120.15	872,773,386.41
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	13,446,975.00	12,515,594.00
Цалингийн урьдчилгаа	1,189,306.00	-
Томилолтын урьдчилгаа	-	3,867,000.00
Урьдчилж гарсан зардал	5,369,890,916.40	2,250,313,315.50
Урьдчилж төлсөн зардал	5,369,890,916.40	2,250,313,315.50
БАРАА МАТЕРИАЛ	97,012,387,817.78	103,315,610,950.06
Түүхий эд материал	58,014,696,059.92	68,195,816,789.64
Тусгай зориулалттай материал	29,107,328,485.06	28,274,259,716.62
Эм боох материал	272,502,127.24	283,054,161.67
Дуусаагүй үйлдвэрлэл	21,586,002,590.53	30,205,360,982.87
Бэлэн бүтээгдэхүүн	7,048,862,857.09	9,433,141,928.48
Хангамжийн материал	30,946,265,302.21	26,226,642,757.15
Бичиг хэргийн материал	1,215,038,735.43	1,377,215,086.32
Аж ахуйн материал	9,371,225,124.48	10,374,196,715.86
Сэлбэг хэрэгсэл	892,094,158.84	1,004,201,546.63
Түлш, шатах тослох материал	3,884,833,570.95	2,760,993,289.70
Барилгын засварын материал	1,680,537,641.45	1,894,292,704.32
Хүнсний материал	4,727,514,920.67	3,877,525,313.76
Малын тэжээл	5,341,315,322.88	224,567,574.12
Баглаа боодол	69,453,661.42	358,983,538.98
Бусад бараа материал	3,764,252,166.09	4,354,666,987.46
Мал амьтад	6,961,545,718.41	7,697,357,567.62
Бусад	1,089,880,737.24	1,195,793,835.65
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	165,154,719,728.42	166,601,972,433.51

ҮНДСЭН ХӨРӨНГӨ	328,128,818,937.74	311,047,804,440.31
Газар	1,250,000.00	1,250,000.00
Биет хөрөнгө	323,086,104,346.76	306,795,420,457.29
Барилга, байгууламж, орон сууц	152,124,212,236.15	165,050,456,813.38
Барилга, байгууламж орон сууц - Анхны өртөг	248,629,956,780.30	264,353,890,327.94
Барилга, байгууламж орон сууц - Хуримтлагдсан элэгдэл	(96,505,744,544.15)	(99,303,433,514.56)
Авто-тээврийн хэрэгсэл	24,889,235,570.92	23,029,001,476.70
Авто-тээврийн хэрэгсэл анхны өртөг - Анхны өртөг	54,675,809,016.14	57,629,960,643.66
Авто-тээврийн хэрэгсэл - Хуримтлагдсан элэгдэл	(29,786,573,445.22)	(34,600,959,166.96)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	45,910,113,133.66	41,758,427,483.97
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	76,277,588,165.19	79,995,301,038.34
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл	(30,367,475,031.53)	(38,236,873,554.37)
Тавилга, аж ахуйн эд хогшил	7,210,875,056.55	7,970,674,004.15
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	14,633,835,290.11	16,129,747,161.36
Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(7,422,960,233.56)	(8,159,073,157.21)
Зам, гүүрийн байгууламж	10,391,368.50	54,765,253.15
Зам, гүүрийн байгууламж - Анхны өртөг	13,204,642.00	84,309,642.00
Зам, гүүрийн байгууламж - Хуримтлагдсан элэгдэл	(2,813,273.50)	(29,544,388.85)
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	34,356,212,998.12	6,268,551,189.83
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж - Анхны өртөг	39,096,322,271.71	11,780,582,222.03
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж - Хуримтлагдсан элэгдэл	(4,740,109,273.59)	(5,512,031,032.20)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	78,164,072.00	81,392,022.00
Бусад үндсэн хөрөнгө	11,228,193,537.11	12,758,659,652.30
Бусад үндсэн хөрөнгө - Анхны өртөг	13,557,120,676.12	16,073,324,682.08
Бусад үндсэн хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(2,924,807,688.59)	(4,073,301,471.60)
Номын фонд	595,880,549.58	758,636,441.82
Дуусаагүй барилга, байгууламж	47,278,706,373.75	49,823,492,561.81
Биет бус хөрөнгө	5,041,464,590.98	4,251,133,983.02
Програм хангамж	4,135,630,341.07	3,635,240,300.72
Програм хангамж - Анхны өртөг	10,876,903,586.97	11,934,335,755.88
Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(6,741,273,245.90)	(8,299,095,455.16)
Бусад биет бус хөрөнгө	905,834,249.91	615,893,682.30
Бусад биет бус хөрөнгө - Анхны өртөг	980,059,341.13	853,412,331.73
Бусад биет бус хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(74,225,091.22)	(237,518,649.43)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	493,283,538,666.16	477,649,776,873.82
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	86,701,944,081.52	75,362,502,625.02
Богино хугацаат зээлийн өглөг	790,162,869.05	36,999,734.00
Төгрөг	790,162,869.05	36,999,734.00
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	753,163,135.05	-
Арилжааны банк	36,999,734.00	36,999,734.00
Өглөг	15,269,184,185.77	17,721,402,724.50
Ажилчидтай холбогдсон тооцоо	33,618,233.30	86,047,442.63
Цалингийн өглөг	518,154.73	2,760,921.00
НДШ-ийн өглөг	2,533,809.00	19,730,220.90
ХАОАТ-ын өглөг	30,566,269.57	63,556,300.73
Бараа үйлчилгээний зардлын тооцоо	7,257,784,633.22	7,130,405,344.05
Гэрэл цахилгааны тооцоо	2,413,973.00	-
Түлш халаалтын тооцоо	16,718,140.00	34,848,314.00
Шуудан холбооны тооцоо	-	6,430,992.88
Цэвэр, бохир усны тооцоо	3,223,962.75	43,333.20

Тээвэр шатахуунын тооцоо	3,758,051.00	6,172,856.00
Хоолын тооцоо	-	5,263,033.50
Эмийн тооцоо	-	1,439,099.67
Байрны түрээсийн тооцоо	-	1,002,041.00
Байрны засварын тооцоо	1,740,000.00	9,407,431.00
Бусад зардлын тооцоо	7,229,930,506.47	7,065,798,242.80
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн тооцоо	78,421,494.48	-
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон тооцоо	66,899,275.40	37,345,191.50
Бусад өглөг	7,832,460,549.37	10,467,604,746.32
Байгууллагад төлөх өглөг	6,962,614,581.82	9,587,287,173.62
Хувь хүмүүст төлөх өглөг	869,845,967.55	880,317,572.70
Урьдчилж орсон орлого	70,642,597,026.70	57,604,100,166.52
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	30,079,989,726.32	29,879,993,670.32
Урсгал	30,079,989,726.32	29,879,993,670.32
Төсөвт байгууллага	16,556,031,376.56	5,963,079,950.67
Урьдчилж орсон орлого	16,556,031,376.56	5,963,079,950.67
Бусад урьдчилж орсон орлого	24,006,575,923.82	21,761,026,545.53
УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨР	-	753,163,135.05
Урт хугацаат зээл	-	753,163,135.05
Төгрөгөөр	-	753,163,135.05
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	-	753,163,135.05
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	86,701,944,081.52	76,115,665,760.07
Засгийн газрын хувь оролцоо	406,581,594,584.64	401,534,111,113.75
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан	249,510,083,826.74	216,859,798,429.16
Хуримтлагдсан үр дүн	94,334,933,976.95	123,867,374,115.71
Өмнөх үеийн үр дүн	94,334,933,976.95	108,022,964,327.50
Тайлант үеийн үр дүн	-	15,844,409,788.21
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	62,736,576,780.95	60,806,938,568.88
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	406,581,594,584.64	401,534,111,113.75
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	493,283,538,666.16	477,649,776,873.82

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
НИЙТ ДҮН	-	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	383,362,406,933.03	405,310,718,082.60
Олон улсын байгууллагын тусламж	4,977,382,226.12	347,643,842.65
Хөрөнгийн тусламж	4,977,382,226.12	347,643,842.65
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	378,385,024,706.91	404,963,074,239.95
Улсын төвлөрсөн төсвөөс	348,725,959,086.61	367,396,163,833.65
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	307,827,161,569.00	325,017,887,095.46
Засгийн газрын нөөц хөрөнгө	231,626,133.40	-
Хөрөнгийн	29,971,324,325.91	26,592,448,931.20
Монгол улсыг хөгжүүлэх сангаас	318,110,000.00	-
Нэмэлт санхүүжилтийн орлого	10,377,737,058.30	15,785,815,306.99
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	354,629,998.50	222,726,265.00
Төсвийн жилийн явцад УИХаас соёрхон баталсан ЗГ хоорондын гэрээ болон ОУбайгуулл	-	301,957,292.00
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	5,275,590,658.00	7,413,328,845.75
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	2,724,432,564.00	1,629,780,665.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	197,926,580.00	4,638,387,339.24
Төсвийн урамшуулал	1,825,157,257.80	1,579,634,900.00
Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт	-	12,500.00
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	6,661,743,780.09	2,535,366,153.18
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	320,807,380.00	71,819,194.42
Засгийн газрын нөөц хөрөнгө	-	4,000,000.00
Хөрөнгийн	6,340,936,400.09	2,459,546,958.76
Төсөвт байгууллагаас	2,515,403,533.33	3,019,704,514.68
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	79,711,248.00	125,260,373.00
Өр барагдуулах санхүүжилтийн орлого	148,985,000.00	-
Хөрөнгийн	2,003,915,535.33	2,888,038,741.68
ТЕЗ-аас олгосон санхүүжилт	282,791,750.00	6,405,400.00
Нийгмийн даатгалын сангаас	2,099,918,577.26	908,417,671.00
ЭМДС-аас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	1,998,301,741.26	626,118,000.00
НДС-ийн шилжүүлэг	64,516,461.00	66,872,671.00
ЭМДС-ийн шилжүүлэг	37,100,375.00	215,427,000.00
Бусад Засгийн газрын тусгай зориулалтын сангаас санхүүжих	18,381,999,729.62	31,103,422,067.44
Төрийн сургалтын санд олгох	9,034,000.00	-
Төрийн албан хаагчын 1 хүүхдийн сургалтын төлбөр	9,034,000.00	-
Гадаад төслийн зээлээс санхүүжих	1,913,262,717.36	-
Тодорхойгүй орлого	16,459,703,012.26	31,103,422,067.44
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	125,690,953,142.74	70,307,455,212.12
Өмчийн орлого	3,704,241.16	-
Хүүгийн орлого	3,704,241.16	-
Бараа, үйлчилгээний борлуулалт	120,079,608,788.41	68,900,500,686.13
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	70,672,308,540.53	68,900,500,686.13
Үндсэн үйл ажиллагааны орлого	35,627,309,664.59	45,502,753,331.16
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	27,599,703,737.21	6,317,815,585.69
Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого	162,138,600.00	-

Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,283,156,538.73	17,079,931,769.28
Захиргааны хураамж	49,407,300,247.88	-
Шүүхийн шийдвэрийн төлбөр	498,886,821.00	-
Бусад захиргааны хураамж	48,908,413,426.88	-
Торгууль, шимтгэл	97,682,550.00	-
Татварын бус бусад орлого	5,509,957,563.17	1,406,954,525.99
Хөрөнгийн орлого	4,765,168,678.84	-
Ангилалдаагүй орлого	744,788,884.33	1,406,954,525.99
Ангилалдаагүй бусад орлого	744,788,884.33	1,406,954,525.99
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	509,053,360,075.77	475,618,173,294.72
АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ	196,464,297,019.26	219,853,990,282.93
Үндсэн болон нэмэгдэл цалин	188,800,716,760.76	211,271,238,032.04
Үндсэн цалин	181,833,948,135.90	200,943,835,910.10
Гэрээт ажилчдын цалин	4,001,230,039.86	8,905,465,319.72
Унаа хоолны хөнгөлөлт	784,681,503.23	1,160,404,707.22
Бусад нэмэгдлүүд	2,180,857,081.77	261,532,095.00
Унаа, болон бусад нөхөн олговор	294,355,783.79	231,487,880.00
Бусад нэмэгдэл	1,886,501,297.98	30,044,215.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	7,663,580,258.50	8,582,752,250.89
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	4,499,546,153.06	4,191,681,712.11
Тэтгэврийн даатгалын шимтгэл	3,849,871,793.40	3,475,810,427.92
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	278,781,897.03	264,066,015.17
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	290,920,606.61	338,123,187.49
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	79,971,856.02	113,682,081.53
